

Сангийн сайдын 2013 оны 05  
дугаар сарын 31-ний өдрийн 125  
дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## **МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

### **ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА  
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

*2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.*  
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар  
2013 он

## ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтад бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)

**“УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК**

БАТЛАВ:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

---

Г.БАЯРСАЙХАН

Огноо: 2020.08.06

**ӨВЛИЙН АЖЛЫН ХУВЦАС НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** *Өвлийн ажлын хувцас*

**Төслийн дугаар:** **ХАБЭА-2020/01**

**Харьцуулалт/  
гэрээний дугаар:** **ХАБЭА-2020/01**

Улаанбаатар хот

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**[Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Өвлийн ажлын хувцас]**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 08-р сарын 17-ны өдрийн 15 цаг 00 минутаас]**-аас өмнө [\[www.tender.gov.mn\]](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 08-р сарын 17]**-ны өдрийн **[15 цаг 30 минут]**<sup>1</sup>-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх.<sup>2</sup> Тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж,  
“Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Өргөтгөлийн 3 давхар байр  
100 тоот өрөө Утас: 75753047-242, 297 Факс: +976-11-342397.]

---

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

<sup>2</sup> Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн бол нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас хуулбар ирүүлэх</li> <li>2. Компанийн танилцуулга ирүүлэх</li> <li>3. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт ирүүлэх</li> <li>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт ирүүлэх</li> <li>5. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх</li> <li>6. Тендер нээсэн өдөр татварын өртэй эсэхийг цахим системээр шалгах тул хуулийн дагуу татвар, хураамжаа бүрэн төлсөн байх</li> <li>7. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, өргүй тухай тодорхойлолт ирүүлэх</li> </ol> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1 дүгээр зүйлд (14.1.1 – 14.1.7) заасан нөхцөл байхгүйг албан бичгээр баталгаажуулж ирүүлэх</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.]</b>  <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягаар ирүүлнэ          Давхар болон өрөөний дугаар: <b>[Өргөтгөлийн 3 давхар байр 100 тоот өрөө]</b>          Огноо: <b>[2020 оны 08 дугаар сарын 17-ны өдөр]</b>          Цаг: <b>[ 15 цаг 00 минут]</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.]</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>[Өргөтгөлийн 3 давхар байр 100 тоот өрөө]</b>          Огноо: <b>[2020 оны 08 дугаар сарын 17-ны өдөр]</b>          Цаг: <b>[15 цаг 30 минут]</b></p>
ТӨӨЗ 3.1 б	<p>Бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулж ирүүлэх</p>
ТӨӨЗ 3.1 в	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн [1] /2019/ жилийн санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй. Учир нь цахим системээс тендер нээсэн өдөр санхүүгийн тайланг татаж шаардлагатай мэдээллийг авна</li> <li>2. Сүүлийн [5] /2015, 2016, 2017, 2018, 2019/ жилийн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэлд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбарууд ирүүлэх. Жил тус бүрд нэг мэдээлэл ирүүлэхэд болно.</li> <li>3. Сүүлийн [1] /2019/ жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 100% хувиас багагүй байх</li> </ol>
ТӨӨЗ 3.1 д	<ul style="list-style-type: none"> <li>• Өвлийн ажлын куртка, өмд нь инженер техникийн ажилтан, засварчин тохируулгын ажилтан тус бүрт өөр өөр байхаар загвар болон өнгөний сонголтыг тохирч батална.</li> <li>• Хувцасны хэмжээг нийлүүлэгч хүн тус бүрээр хэмжиж авах ба хэмжээг гэрээ байгуулсаны дараа өгнө.</li> <li>• Материал нь куртканы зориулалтын салхи, ус нэвтрэхгүй агаарын болон дулаан солилцоог хангасан, бөөгнөрөхгүй, агшихгүй, өнгө алдаж будаг гардаггүй, хөлс гадагшлуулах болон чанар стандартын бусад шаардлагагуудыг хангасан байхаар сонгоно.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын куртка өмд нь ажил үйлчилгээ хийхэд биед эвтэйхэн, хүнд хүчир ажил үйлчилгээ хийхэд хөдөлгөөнд саадгүй чөлөөтэй, 2 болон 3 давхар оёдолтой, оёдлын төгсгөл давхар бэхэлгээтэй оёдолтой байна.</li> <li>• Өвлийн ажлын өмдний салтаа нь сул чөлөөтэй, нурууны хамгаалалттай, мөрөвчтэй, дээшээ өндөр суулттай бүстэй байна.</li> <li>• Ажлын куртка нь дулаахан, давхар дотортой, хөдөлгөөнд саадгүй чөлөөтэй, хунирахгүй таталдахгүй, ханцуй нь чөлөөтэй, барихгүй байна.</li> <li>• Ажлын куртканы дотор нь ширээстэй, дулаан алдахгүй, биед наалдсан эвтэйхэн, хөлс гадагшлуулах малгай нь магнай давсан чөлөөтэй байна.</li> <li>• Материал нь мэргэжлийн онцлогт нийцсэн бат бөх чанартай байна. Материалын дээжийг Сорилын төвийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, материалын орц, ширхэгжилтийн бүрэлдхүүний сорилтын дүн гүйцэтгэлийг ирүүлэх.</li> <li>• Компаний лого тэмдэг, тодруулагч цацруулагчийн хэмжээ, халаасны хэмжээ хэлбэрийг тохирч хийнэ.</li> </ul> <p><b>Бусад шаардлагууд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Өвлийн ажлын хувцас куртка, өмдний хослол бэлтгэн нийлүүлэх компани нь өөрийн гэсэн үйлдвэрлэлийн ажлын байртай /ажлын байрны фото зургийг ирүүлнэ /технологийн дагуу 2 болон 3 хосоор оёх оёдлын суурь машинтай, оёдол хийх иж бүрэн тоног төхөөрөмжтэй байх фото зургийг ирүүлнэ/</li> <li>• Орон тооны мэргэжлийн загвар зохион бүтээгч / мэргэжлийн диплом зураг ирүүлэх/ багадаа мэргэжлийн 8-н оёдолчинтой байх/</li> <li>• 200 хүний өвлийн ажлын хувцас ажлын куртка, өмдний хослолыг ажлын 20 хоногт хийж гүйцэтгэх хүчин чадалтай байх /Энэ тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлнэ./</li> <li>• Өвлийн ажлын хувцасны төрөл тус бүрээс нэг дээж загварыг захиалагчаас өгсөн загвар зургын дагуу оёж, тендер нээхээс өмнө ирүүлэх</li> </ul>
<b>ТӨӨЗ 3.1 д</b>	Захиалагчийн тавьсан шаардлагыг бүрэн хангасан өвлийн ажлын хувцсыг тоо хэмжээгээр оёж, гэрээт хугацаанд нийлүүлэх тухай албан мэдэгдэл ирүүлнэ
<b>ТӨӨЗ 3.1 д</b>	Бараа хүргэх эцсийн цэг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байрны агуулах
<b>ТӨӨЗ 7.2</b>	Өвлийн ажлын хувцасны нийт хэмжээ: Инженер техникийн ажилчид 63 хос, засварчид 120 хос, нийт 183 хос байна.

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Өвлийн ажлын хувцасны техникийн тодорхойлолтыг ТШӨХ-д заасан. Өвлийн ажлын хувцасны загварыг тендерийн баримт бичигт хавсаргасан болно.
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. [ *Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартыг хангасан байна* ]
3. **Баглаа, боодол:** [ Хувцасыг хос тус бүрээр савалсан байна. ]
4. **Бараа хүргэх газар:** [ Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байрны агуулах ]
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмж их нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Өвлийн ажлын хувцас “ИТА”	Техникийн тодорхойлолт тод заасан	63	Хос	УБДС ТӨХК төв байрны агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 15 хоног	Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 20 хоног	
Өвлийн ажлын хувцас “Засварчид”	Техникийн тодорхойлолт тод заасан	120	Хос	УБДС ТӨХК төв байрны агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 15 хоног	Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 20 хоног	

**Санамж:** Бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулж ирүүлнэ. Тендерт оролцогч 8-р баганыг бөглөнө. 1, 2, 3, 4, 5, 6, 7-р баганын мэдээллийг өөрчлөхийг хориглоно.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК**-ний  
гүйцэтгэх захирал Г.Баярсайхан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Өвлийн ажлын хувцас "ИТА"							
Өвлийн ажлын хувцас "Засварчид"							
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[0,5]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах          | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Өвлийн ажлын гутлыг захиалагчийн ажлын байранд туршиж акт үйлдэн хүлээн авна  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Баталгаат засварын хугацаа <b>0,5</b> жил байна]</p>  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>[100%]<sup>3</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>4</sup></b>                  | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний хугацаа хэтэрсэн хоног тутмад <b>[0,1 хувь]</b></p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн <b>[10 хувь]</b> байна</p>   |

<sup>3</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>4</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>5</sup>

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-аас \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>6</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>5</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>6</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

# УБДС ТӨХК

ИТА-ын өвлийн хослол




Гадаад байдлын техникийн зураг



# УБДС ТӨХК

ИТА-ын өвлийн хослол



Гадаад байдлын техникийн зураг



# УБДС ТӨХК

Ажилчидын өвлийн хослол

Гадаад байдлын техникийн зураг



 R26 G136 B213

 R10 G8 B73

# УБДС ТӨХК

Ажилчдын өвлийн хослол

Гадаад байдлын техникийн зураг

